



ЭРЧИМ МЭДЭЭ

“ДЦС-4” ТӨХК-ний сар тутмын сонин

№ 09 (19)

2012 оны 9-р сар

“ДЦС-4” ТӨХК

“ЭРЧИМ” ХӨЛБӨМБӨГИЙН КЛУБ “Ногоон талбай”-н нээлт

Бид та бүхний санал болгосон материалаас дараа дараагийн дугаарт нийтлэх болно.

Мөн ажиллагчдын санал, шүүмж, оновчтой санал зэргийг сурталчлах болно.

Манай сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2156 дугаарын утас эсвэл Судалгаа Хөгжлийн Албанд файлаар болон бичгээр өгч болно.

Та бүхэнтэй хамтарч ажиллахад хэзээд бэлэн байх болно.

2012 оны 9 дүгээр сарын 3 ны билэгт сайн өдөр Монголын хөлбөмбөгийн хөгжлийн 53 жилийн түүхэнд байгуулагдаад 18 жилийнхээ нүүрийг үзэж буй “Эрчим” клуб анх удаа Европ стандартын ногоон зүлгэн талбайг байгуулж нээлтийнхээ ажиллагааг хийлээ.

“Эрчим” клуб нь өнөөдөр МХБХ-нд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн клубуудын анхдагч нь бөгөөд энэ онд Азийн хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит цомын тэмцээнд анх удаа мэргэжлийн клубуудээс эх орноо төлөөлөн оролцож анхны оноог авч чадсан.



Энэ дугаарт:

2-р нүүрт

**БҮГД НАЙРАМДАХ
ЧЕХ УЛСЫН ЭЛЧИН
САЙД “ДЦС-4” ТӨХК-Д
АЙЛЧЛАВ**

**АХМАДЫН
ХОРОО 2012 ОНД
АХМАДУУДЫН ДУНД
ОЛОН ТАЛТ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ
ИРЛЭЭ**

3-р нүүрт

**2012 ОНЫ 8-Р
САРЫН ТЕХНИК
ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

4-р нүүрт

**ТЕХНИК ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН 2012 ОНЫ
08-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

5-р нүүрт

**ГАЗРААС УРГАСАН
АЛТ “САМАР”**

6-р нүүрт

СОНИН ХАЧИН

**МАЙЯЧУУДЫН ЗӨГНӨЛ
ЮУ ӨГҮҮЛНЭ ВЭ**



15-ны хооронд өөрийн шинэ талбай дээрээ зохион байгуулагдсан “Монголын хөлбөмбөгийн холбооны Цом”-ын аварга шалгаруулах тэмцээнд оролцож нэг ч хожигдолгүйгээр аваргын алтан медаль, цом, өргөмжлөлийг итгэл төгс хүртлээ.

“Үндэсний дээд Лиг”-н тэмцээнээс 1 хүрэл, 3 мөнгө, 6 алтан медаль хүртэж байсан. Манай клуб энэ онд 16 дахь удаагаа зохион байгуулагдсан энэхүү нэр хүндтэй өндөр зэрэглэлийн тэмцээнээс 7 дахь удаагийнхаа аваргын алтан медаль, цомыг гардаж авлаа.

Мөн энэ сарын 4-өөс



БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ЭЛЧИН САЙД “ДЦС-4” ТӨХК-Д АЙЛЧЛАВ

2012 оны 9-р сарын 25-ны өдөр Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Иванна Гроллова тус станцад айлчлав. Айлчлалын хүрээнд хатагтай элчин сайд компанийн Гүйцэтгэх захирал Б.Цэвээнтэй уулзаж Чех улсаас манай станцад хэрэгжүүлсэн төслийн үр дүн, одоо хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаатай танилцахаар ТДЦ ба ХЦ-ээр зочлов.



АХМАДЫН ХОРОО 2012 ОНД АХМАДУУДЫН ДУНД ОЛОН ТАЛТ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРЛЭЭ



Ахмадуудаа жил бүр хамтын гэрээний дагуу тэтгэмж тусламж, урамшуулал хөнгөлөлт олгож байна.

“Эрчимийн ахмад” өрөөг тогтмол ажиллуулж ахмадуудыг эрхэлж байсан албан тушаалаар нь хүлээн авч чөлөөт ярилцлага, уулзалт зохион байгуулж байна. Мөн тэаргүүлэгчдын болон бусад цугларалт хурлыг хийж байна. Ахмадуудаас биеэрээ ирж ахмадын хороонд гаргаж байгаа санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байна.

Дулааны улиралд станцын ногоон талбайд байдаг ахмадын талбайг “Нахиа” багийг ажиллуулж мод өвсийг арчиллах, цэцэг тарих услах зэрэг ажлыг хийж байна.

Явган аялалын “Тэмүүлэл” багийг ажиллуулж сар бүр Улаанбаатар хотын уул нуруудаар ахмадууд аялаж байна.

Уламжлал болсон ажлуудын нэг нь жилд 2 удаа бүх ахмадыг гүйцэтгэх захирлын хэмжээнд хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг ажил

юм. 2012 оны 9-р сарын 28-нд олон улсын ахмадын өдөр эрчим хүчний 90 жилийн ойг тохиолдуулан станцын захиргаа ахмадын хороо ахмадуудаа хүлээн авч дараахь ажлыг зохион байгуулж хийлээ.

Станцын удирдлага ахмадуудаа станцын өнөөгийн байдал, цаашид юу хийх зорилгоо танилцуулж ахмадуудаас санал хүсэлтийг нь сонслоо. Ахмадуудаас 5 ахмад станцын “Хүндэт ажилтан” цол тэмдэг, 4 ахмад Монгол Улсын Ахмадын холбооны “Хүндэт” тэмдэг, 20 хүн байгууллагын мөнгөн шагналаар шагнагдсанаас, 26 ахмадад ахмадын хорооны тодорхойлолтыг үндэслэж гүйцэтгэх захирлын санаачлагаар олголоо.

Урлагийн богино хэмжээний тоглолт үзүүлж хүндэтгэлийн зоог барилаа.



Ахмадын хороо

“ДЦС-4” ХК-ИЙН 2012 ОНЫ 8-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд		Нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт				
					%	Өссөн	Буурсан	хэт/+/ хэм/-/	
ТЭЭ-н гол үзүүлэлтүүд	Боловсруулсан ЦЭХ		сая.кВтц	235,8	253,1		17,3		
	Түгээсэн	ЦЭХ	сая.кВтц	219,6	221,1	100,7			
		ДЭХ	мян. Гкал	114,1	114,1	100,0			
	ДХЦЭХ-ний зарцуулалт		%	12,94	12,65				-0,29
	Түлшний хувийн зарцуулалт	цахилгаанд	гр/кВтц	371,364	371,335				-0,028
		дулаанд	кг/Гкал	181,38	180,106				-1,274
	Бодит түлш	мазут	тн	120	75				-45
		нүүрс	мян.тн	243,7	243,4				-0,3
	Жишмэл түлш	хэтрэлт	тжт						
		хэмнэлт	тжт		151				
Уур усны алдагдал		%	6,0	5,64			0,4		
Диспетчерийн графикийн барилт	цахилгаан	сая.кВтц		1,5					
	дулаан	мян. Гкал							
Горим параметр	Зуухны параметр	даралт	ата	138	139		1		
		халуун	°С	555	555			2	
	Тэжээлийн усны халуун		°С	225	225				
	Вакуум		%	86,69	82,69			4,00	
	Зуухны галлагаа	халуун	тоо	1	3		2		
		хүйтэн	тоо	3	4		1		
бүгд		тоо	4	7		3			
Хүчин чадал ашиглалт	Турбины	цахилгаан	%	58,69	63,00		4,31		
		дулаан	%		16,61				
	Зуухны		%		43,95				
	Суурилагдсан ХЧА цаг	цахилгаан	цаг	436,65	468,73		32,08		
		дулаан	цаг		123,58				
	Дундач ачаалал	зуухны	т/ц		314				
турбины		МВт/ц	316,93	340,21		23,28			
Зогсолт	зуухны	тоо	0	7		7			
	турбины	тоо	3	5		2			
Ажилласан тоноглолын тоо	зуухны	тоо	4	4,97		0,97			
	турбины	тоо	4	4,01		0,01			
СПОТ зах зээл	Худалдаж авсан ЦЭХ		мян. кВтц		-				
			мян.₮		-				
	Худалдсан ЦЭХ		мян. кВтц		306,06				Авлага: 19724,667₮
			мян.₮		19724,67₮				

ТЕХНИК ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2012 ОНЫ 08-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Үндсэн тоноглол зогсолт

2012 оны 08-р сард станцын хэмжээний аваари, 1, 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 11 бүртгэгдсэнээс зуух 7 удаа, турбин 4 удаа тус тус зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

Үндсэн тоноглол зогссон шалтгааныг ангилан үзвэл:

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2012 оны 07-р сар									
1	Зуух	-	1	1	2	1	-	-	4	2	7
2	Турбин	-	-	-	3	1	-	2	1	3	4
Дүн		-	1	1	5	2	-	2	5	5	11

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолын гэмтэлд тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-3 /22.412,797 мян₮/, бүгд-3, Мазут зарцуулалтын акт: ЦЦ-2 /7.959,475 мян₮/, ДХХАЦ-1 /5.487,66 мян₮/, бүгд-3, Тоног төхөөрөмж, сэлбэг материалыг ашиглалтаас хасах акт: ТЦ-1 /900,0 мян₮/, ЦЦ-1 /24.465,4 мян₮/, НАХ-1 /261,0 мян₮/, бүгд-3, Уур усны горимын зөрчлийн акт: ТЦ-1, бүгд-1, Нийт 10 ширхэг акт тогтоогдлоо.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар :

•08-р сарын 13-ны өдөр Хими цехийн компрессорын зааланд галын булан, ПК болон гэрэлтүүлгийн щитокуудыг хааж нүүрсэн шүүгч хураасан байсан зөрчлийг арилгуулсан.

8-р сарын 14-ний өдөр "ALLIANCE TECH" ХХК-ийн нарядгүй ажиллаж байгаа хүмүүсийн тоог гарган ХАБ зөрчлүүдийг нэгтгэж Ерөнхий инженерт танилцуулсан бөгөөд тухайн компанид зөрчлийг арилгах талаар АЛБАН ШААРДЛАГА өгч, зөрчлийг арилгуулсан.

8-р сарын 29-ний өдөр УНС 84-02 улсын дугаартай машин төмөр каркас тэвшнээсээ илүү гаргаж ачаа ачсан, үйлдвэрийн зам талбайд хурд хэтрүүлэн явсан тул машиныг зогсоож, жолоочид нь АНХААРУУЛГА өгч, зөрчлийг засуулсан.

8-р сарын 20-ны өдөр Механик цехийн ШБХ-ийн засварчин Л.Мягмарсүрэн 20 цаг 50 минутанд орой дуудагдаж ирсэн боловч 23 цагт даралт өндөр (170/110) байсан тул гэр рүү нь буцаасан бөгөөд энэ тухай МЦ-ийн ээлжийн дарга Б.Сүхбаатар нь энэ тухай холбогдох хүмүүст МЭДЭЭЛЭЭГҮЙ, ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРНАЛД ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ ҮЗЭГЛЭЭГҮЙ байсан тул хариуцлагын төлбөр ноогдуулсан.

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (дБ)		Ажлын байрны халуун (°C)		Ажлын байрны чийглэг %		Ажлын байрны тоосролт (мг/м³)		Тайлбар	
		2011-8 сар	2012-8 сар	2011-8 сар	2012-8 сар	2011-8 сар	2012-8 сар	2011-8 сар	2012-8 сар		
1	ТДЦ	81,0	80,0	24,2	24,4	34,5	33,4	23,8	23,4		
2	ЗЦ	87,2	86,4	33,1	32,1	28,6	29,1	18,7	16,6		
3	ТЦ	82,3	84,3	33,9	31,2	31,7	32,3	танцын дундаж 21.3 мг/м³	Станцын дундаж 20.0 мг/м³		
4	Хими	70,2	70,4	29,5	27,2	35,0	35,3				
5	Механик	73,1	72,4	27,0	25,1	33,8	34,4				

Техник хяналтын хэлтэс

Самарнаас хаях зүйлгүй, байгалийн цэвэр алт гэж хэлэхэд илүүдэхгүй. Түүхийн хуудаснаа самрыг анх 7800 жилийн тэртээгээс хүмүүс хүнсэндээ хэрэглэж ирсэн хэмээн үздэг бөгөөд мөн эртний хүмүүсийн эд өлгийн зүйлсээс самар хагалах багаж зэвсэг олдож байсан нь гайхалтай. Манай улс хуш модны самарнаас гадна гадаад улсаас импортоор маш олон төрлийн самрыг оруулж ирдэг. Сүүлийн үед самраас хүний биед ашигтэй бичил элемент илрүүлээд байна. Магни, зэс, фосфор, иод, төмөр зэргийг нэрлэж болно. Бүх төрлийн самар адил шим тэжээлтэй бөгөөд төрлөөсөө хамаарч 46-76% тос, 8-24%-ийн уураг агуулдаг учир ургамлын тосны эх үүсвэр болдог. Нийт тосных нь хагас хувийг ханаагүй тосны хүчил эзэлдэг бөгөөд эслэг, антиоксидант бодис, А, Е, В аминдэм, кали, кальци, селенээр нэн баялаг юм. Судлаачид самрын тогтмол хэрэглээ нь цусны холестеролийн түвшинг багасгаж зүрх судасны эрсдлийг бууруулдаг болохыг тогтоожээ. Цусан дахь сахарын хэмжээг нэмэгдүүлддэггүй тул чихрийн шижин өвчний үед хэрэглэх нь тохиромжтой.

Өдөрт хэрэглэх зөвлөмж хэмжээ

Хөхүүл болон жирэмсэн эмэгтэйчүүдийн өдөрт хэрэглэх хэмжээг 4-5 нэгж буюу 60-75гр-аас хэтрүүлэлгүй хэрэглэхийг зөвлөдөг.

Насан хүрсэн хүний өдөрт хэрэглэх норм хэмжээ нь 45 гр хэрэглэхийг зөвлөдөг.



Хушга: Хушга нь тосыг өөртөө хамгийн ихээр агуулдаг бөгөөд омега-3 тосны хүчлээр нэн баялаг. Мөн элгийг маш сайн хамгаалдаг бөгөөд дархлааны үйл ажиллагааг сайжруулдаг байна. Мөн стрессийг багасгаж нойр хүргэхээс гадна цус багадалттай тэмцэх хамгийн сайн бүтээгддэхүүн юм.



Бразил самар: Селен, магни төмрийн агууламжтайгаас гадна олон төрлийн аминдэмийг өөртөө агуулдаг. Хөгшрөлт болон хорт хавдрын

эсрэг үйлчилгээтэй тул та үргэлж залуугаараа байхыг хүсвэл бразил самрыг хүнсэндээ хэрэглэхийг зөвлөө.



урьдчилан сэргийлнэ.

Ангаахай самар: Кальци болон төмрөөр баялаг тул яс сийрэгжилт болон цус багадах өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Мөн түүнчлэн уураг тархины үйл ажиллагааг эрчимжүүлж, зүрх судасны өвчнөөс



төрлийн аминдэмээр нэн баялаг. Мөн бамбай булчирхайн үйл ажиллагааг сайжруулахаас гадна, эхийн сүүг саамшуулах шим тэжээлт амин хүчил ихээр агуулдаг.

Хушны самар: Самрын чөмөгний найрлаганд тос 59,9%, уураг 19,6%, нүүрс ус 16,7% байдаг. Уураг нь хүний биед түргэн шингэх онцгой ач холбогдолтой. Хушны самар нь бүх



Газрын самар: Уураг өөх тос, нүүрс усаар баялаг бөгөөд бие махбодын бодисын солилцоог сайжруулж мөн цусан дахь холестеринийг бууруулна.

Анхаарах зүйл: Судлагаагаар АНУ-ийн нийт хүн амын бараг 1%-ыг самрын харшилтай хүмүүс эзэлдэг. Самар нь харшил үүсгэгч хүнсний бүтээгдэхүүн бөгөөд тухайн бүтээгдэхүүнд харшилдаг бол самар болон түүгээр хийсэн хүнсийг хэрэглэхгүй байхыг зөвлөө.

СОНИН ХАЧИН

Үс хусах нь түүний ургалтад нөлөөлнө



Ихэнхи хүмүүс үзэхдээ үс хусвал түүний ургалт хурдасч илүү өтгөн, ширүүн ургадаг гэж ойлгодог. Тэгвэл энэ тийм биш юм байна. 1920-оод оны үед хийсэн судалгаагаар үс хусах нь түүний ургал-

танд ямар ч нөлөөгүй хэмээн гарсан аж. Үсний ургалтыг арьсан дор байдаг үсний хүүдий зохихуулдаг байна. Гэсэн хэдий ч зүгээр хусахад үсний хүүдийн үйл ажиллагааг өөрчлөх боломжгүй юм.

Хэрвээ спортоор хичээллэхээ больвол булчин өөх болж хувирна



Булчин болон өөх нь хоёр өөр төрлийн бүтэц, үүрэгтэй зүйлс юм. Спортоор хичээллэхэд булчин их томордог. Өөрөөр хэлбэл, булчингийн эсийг нэмэх бус харин булчингийн хэмжээ нь л томордог байна. Харин хүн спортоор хичээллэхээ больсны дараа булчин өөх болдоггүй бөгөөд харин булчингийн эс агшиж жижиг болдог аж. Спортоор хичээллэж байх үедээ хүн маш их энерги зарцуулдаг учраас их иддэг. Харин спортоор хичээллэхээ больсны дараа илүүдэл илчлэгийг зарцуулж чадаагүй нь улмаас хүний жин нэмэгддэг байна. Энэ нь булчин өөх болж байгаа шинж биш юм.

Хэрвээ бид тархины 10%-ийг л ашигладаг



Энэхүү хачирхалтай зүйл олон жилийн өмнөөс тарж эхэлсэн. Эрдэмтэд тархины маш олон судалгаа хийсэн бөгөөд судалгаанаас харахад хүүний тархинд ажилладаггүй хэсэг гэж огт үгүй байлаа. Хэрвээ бид тархины 10%-ийг л ашигладаг

байсан бол бага зэргийн гэмтэл бидэнд төдийлөн нөлөөлөхгүй л байсан болов уу. Тиймээс бид тархиныхаа 100%-ийг ашигладаг. Заримдаа тархиныхаа ихэнхи хэсгийг гэмтээсэн хүн эрүүл байж чаддаг. Гэхдээ энэ бол 1000-д ганц тохиолдох ховор зүйл юм.

МАЙЯЧУУДЫН ЗӨГНӨЛ ЮУ ӨГҮҮЛНЭ ВЭ

2012 оны арванхоёрдугаар сарын 21-нд юу болох вэ хэмээн дэлхий нийтээрээ шуугицгааж байна. Энэ дуулианы гол эзэн нь майячууд юм. Учир нь 2006 оны тавдугаар сард "2012 он-Кетцалькоатель буцаж ирнэ" ном хэвлэгдэж, алдарт жүжигчин Мел Гибсон эртний майячуудын соёл иргэншилтэй холбоотой "Апокалипсис" кино бүтээсэн нь дэлхий нийтийн анхаарлыг майячуудын зөгнөлд хандуулж чадсан юм. Майячуудын сүмийн хананд үлдээсэн цаг тооны бичээсийг судалсан эрдэмтэд 13 бактуны тоолол МЭӨ 3113 оны наймдугаар сарын 13-нд эхэлснийг тогтоожээ. Нэг бактун нь 114 мянган өдөртэй тэнцэх хугацаа бөгөөд 13 бактун гэдэг нь 5125 жилтэй дүйцнэ.

Энэ нь одон орны 26 мянган жилийн давтамжтай явагддаг үзэгдлийн тавны нэг юм. Тэгэхээр 13 бактуныг МЭӨ 3113 оны наймдугаар сарын 13-нд эхэлсэн гэж үзвэл 2012 оны арванхоёрдугаар сарын 21-нд дуусах аж. Майягийн цаг тооны бичгээр бол энэ өдөр 13.0.0.0.0 хэмээн бичигдэнэ. Ийн цаг тоолол тэглэх тохиолдол бүрт онцгой үйл явдал болдог учраас майячууд энэ өдрийг онцгойлон тэмдэглэжээ. Майячуудын тооцоогоор бол 2012 оны арванхоёрдугаар сарын 21-нд "Дөрөвдүгээр нарны эрин" өндөрлөж, "Тавдугаар нарны эрин" буюу "Цагаан ирвэс"-ийн эрин эхэлнэ. Улаан, цагаан, хар, шар ирвэс гэж байдаг. Тэд бүх соёл иргэншлийн эцэг хэмээн майячууд тодорхойлжээ.

Харин эрт дээр үед цагаан ирвэс зулзагагүй байсан ч янз бүрийн өнгөтэй зулзагууд дэлхийн төгсгөлд төрж, газар дэлхийн өнцөг булан бүрт амьдарна гэж индианы домогт өгүүлдэг. Энэ домгоор бол хүмүүсийг эхлээд шавраар бүтээсэн ч усанд норж, бодож сэтгэж чаддаггүй байсан учир хулсаар бүтээжээ. Тэд өсч үржин өнөр өтгөн болоод өөрсдийгөө бүтээсэн ачтанаа мартсан учраас галав юүлж газар дэлхийг цэвэрлэдэг. Ойд амьдардаг сармагчингууд энэхүү хоёрдугаар үеийн хүмүүсийн үлдэгдэл гэнэ. Гурав дахь удаагаа хүмүүсийг эрдэнэшишээр бүтээж тэнгэрийн цус судсаар нь гүйлгэсэн байна. Тэрхүү эрдэнэшишээр бүтээгдсэн хүмүүс нь өнөөдрийн хүн төрөлхтөн гэж майячуудын зөгнөлд бичжээ. Тэдний тооцоолсон цаг хугацааны хувьд ус, ирвэс, салхины эрин өнгөрч газрын эрин өндөрлөх гэж буй. Эрин солигдох мөч бүрт ихээхэн сүйрэл болж, газар хөдөлж, хүмүүс үхэж, таагүй зүйл болдог гэж майячууд тэмдэглэн үлдээсэн байна.

ШИНЭ ЭРИНИЙ ЭХЛЭЛ БА ШИНЭ АМЬДРАЛ

Майячууд 2012 оны арванхоёрдугаар сарын 21-нд нэг эрин төгсөнө гэснээс бус ертөнцийн төгсгөл ирнэ гэж зөгнөөгүй. Одон орны өргөн дэлгэр мэдлэгтэй байсан энэ ард түмэн шинэ эриний эхлэлийг "Сүүн зам" буюу тэнгэрийн заадастай холбон тайлбарлажээ. "Сүүн зам" галактикийн диаметрт 400 гаруй тэрбум од бөөгнөрсөн байдаг. Энэ бөөгнөрөл энгийн нүдэнд харанхуй тэнгэрийн дундуур зүссэн зураас мэт үзэгддэгээс сүүн зам гэгдэх болжээ. Гэтэл энэ их бөөгнөрөл дунд, галактикийн яг төвд нь том хэмжээтэй хар нүх байдгийг эрдэмтэд орчин үеийн дуран авай ашиглан нээж алмайран гайхсан юм.